

БАТЛАВ.
ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН
ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

М.БАЯРАА

**МОНГОЛ УЛСАД БАРИЛГЫН САЛБАР ҮҮСЭЖ ХӨГЖСӨНИЙ
100 ЖИЛИЙН ОЙН ЛОГО БҮТЭЭХ
УРАЛДААНЫ УДИРДАМЖ**

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсад орчин цагийн барилгын салбар үүсэж хөгжсөний 100 жилийн ой тохиож буйтай холбогдуулан түүхэн замнал, хөгжлийн ололт амжилт, ирээдүйн чиг хандлагыг илэрхийлэх албан ёсны бэлгэдэл (лого)-г бүтээх зорилгоор нээлттэй уралдаан зарлаж байна.

ХОЁР. УРАЛДААНЫ ЗОРИЛГО

- Барилгын салбарын 100 жилийн түүх, үнэ цэнэ, хөгжлийн үзэл санааг илэрхийлэх орчин үеийн дизайн бүхий логотой болох
- 100 жилийн ойн хүрээнд зохион байгуулах бүх арга хэмжээ, хэвлэл мэдээлэл, дижитал болон хэвлэмэл бүтээгдэхүүнд нэг стандартаар ашиглах боломжтой бэлгэдэл логотой болох

ГУРАВ. ЛОГОД ТАВИГДАХ ҮНДСЭН ШААРДЛАГА

3.1 Агуулгын шаардлага

Лого нь дараах утгыг илэрхийлсэн байна:

- Монгол Улсын барилгын салбарын хөгжил, тогтвортой байдал, бүтээн байгуулалт, ирээдүй
- 100 жилийн ой (1926–2026 он)
- Үндэсний онцлог, орчин үеийн шийдлийн хослол

3.2 Дизайны шаардлага

- Энгийн, ойлгомжтой, давтагдашгүй шийдэлтэй
- Том, жижиг хэмжээнд (баннер, товч, хэвлэл, дижитал) ялгарах
- Өнгөт болон хар-цагаан хувилбарт хэрэглэх боломжтой

3.3 Текстийн шаардлага

Логод дараах бичвэр орсон байж болно:

- “Монгол Улсын барилгын салбар – 100 жил”
- “Construction Sector of Mongolia – 100 Years”
(Монгол, англи хэлний аль нэг эсвэл хосолсон хэлбэр байж болно)

ДӨРӨВ. ТЕХНИК ШААРДЛАГА

Оролцогч дараах материалыг бүрдүүлнэ:

4.1. ВЕКТОР ФАЙЛ

Лого нь вектор форматтай байх ба дараах өргөтгөлүүдийн аль нэгээр ирүүлнэ:

- ✓ AI (Adobe Illustrator)
- ✓ EPS
- ✓ SVG

4.2. ЗУРГИЙН ФАЙЛ

Логог дараах зураг форматтай хавсаргана:

- ✓ PNG – background-гүй (тунгалаг)
- ✓ JPG – цагаан background-тай
- ✓ Техникийн үзүүлэлт: Нягтаршил: 300 dpi, Өргөн: хамгийн багадаа 3000 рх байх ба Өнгөт хувилбар, хар-цагаан хувилбар, нэг өнгийн (моно) хувилбар байвал давуу тал

4.3. Тайлбар бичвэр (1 хуудас)

4.4. Логоны санаа, бэлгэдэл, утга агуулгын тайлбар

4.5. Хэрэглээний жишээ /Баннер, постер, үнэмлэх, сошиал пост дээрх жишээ/

ТАВ. ОРОЛЦОГЧДОД ТАВИГДАХ ШААРДЛАГА

- дизайнер, зураач, уран бүтээлч, салбарын мэргэжилтнүүд, Иргэн, хуулийн этгээд оролцох боломжтой.
- Нэг оролцогч 1–3 хүртэлх бүтээл ирүүлж болно
- Бүтээл нь бусдын зохиогчийн эрх зөрчөөгүй, өмнө нь ашиглагдаагүй байх

ЗУРГАА. ШАЛГАРУУЛАЛТЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

№	Шалгуур	Үзүүлэлт
1	Агуулгын илэрхийлэл, бэлгэдэл	30%
2	Дизайны чанар, бүтээлч байдал	25%
3	Үндэсний ба орчин үеийн хослол	20%
4	Ашиглах боломж, уян хатан байдал	15%
5	Танигдах чадвар, онцлог	10%

ДОЛОО. ШАГНАЛ, УРАМШУУЛАЛ

Түрүүлсэн лого нь Барилгын салбарын 100 жилийн ойн албан ёсны лого болно.

/Өргөмжлөл, мөнгөн шагнал, үнэ бүхий зүйл/

НАЙМ. ЗОХИОГЧИЙН ЭРХ

- Шалгарсан логоны онцгой ашиглах эрхийг зохион байгуулагч байгууллага эзэмшинэ.
- Зохиогчийн нэрийг албан ёсоор дурдана.
- Логоны дизайн дээр жижиг засвар, адаптаци хийх эрх зохион байгуулагчид хадгалагдана.

ЕС. ХУГАЦАА, ХАЯГ

- Материал хүлээн авах: 2026.01.14 –2026.01.27
- Шалгаруулалт: 2026.01.29
- Илгээх хаяг: info@mudch.gov.mn

АРАВ. ХОЛБОО БАРИХ

- Холбоо барих утас:51-261429
- И-мэйл: info@mudch.gov.mn
- Веб сайт: Mscud.gov.mn

ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСЭГ